



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 2/580

Мөрөн сум

Захирамжийн холбогдох хэсгийг  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 48 дугаар зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дахь зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Захирамжид өөрчлөлт оруулах тухай” аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/274 дүгээр захирамжийн хавсралтын 1 дэх хэсэгт заасан Мөрөн сумын 1 дүгээр баг Гандангийн баруун талд байршилтай 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай газрыг мод үржүүлгийн зориулалтаар өөрчлөн эзэмшүүлсэн хэсгийг хүчингүй болгож 6712015020 нэгж талбарын дугаартай 9806м<sup>2</sup> газрыг эзэмшигч иргэн Ач хариад овгийн Лааганы Цэрэнжав (РЮ59012111)-ын эзэмшил газрын зориулалтыг “5-8 давхар нийтийн орон сууц”-ны зориулалттайгаар хэвээр үлдээн, газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг үргэлжлүүлэн 11 жилийн хугацаатайгаар захирамжид өөрчлөлт оруулан эзэмшүүлсүгэй.

2.Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/274 дүгээр захирамжийн хавсралтын 2 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

3.Дээрх захирамжаар газрын кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулж газар эзэмшигч иргэн Лааганы Цэрэнжав (РЮ59012111)-тай газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ